

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2014 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 18 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү тогтоол нь ус хангамж, ариутгах татуургын чиглэл /нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх/-ээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй байдалд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Нөхцөл, шаардлага нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгээс бүрдэнэ.

Хоёр. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг, тусгай зөвшөөрөл олгох

2.1 Ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж байгууллага нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

2.1.1 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааны төрөл, ангиллыг тодорхой зааж, тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл

2.1.2 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ,

2.1.3 Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, /тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гарч, улсын тэмдэгтийн хураамж төлснөөр тусгай зөвшөөрөл олгогдоно./

/Энэ заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

2.1.4 Холбогдох байгууллагын ус ашиглах тухай дүгнэлт, зөвшөөрөл,

2.1.5 Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд Гадаадын хөрөнгө оруулалтын газраас олгосон гэрчилгээний хуулбар, тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар,

2.1.6 Аж ахуйн нэгж байгууллагын сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан тэнцэл, аудитын дүгнэлт, татварын байгууллагын тодорхойлолт, шинээр байгуулагдаж байгаа аж ахуйн нэгжийн хувьд эхлэлтийн баланс, мөн Зохицуулах зөвлөлөөс батлагдсан маягтын дагуу жил, улирлаар гаргасан үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээллийг ирүүлнэ.

/Энэ заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан. /

2.1.7 Инженер техникийн ажилтан нэг бүрийн диплом, гэрчилгээ, батламж, зөвлөх инженерийн гэрчилгээний хуулбар, мэргэшсэн инженерийн мэргэшлийн зэргийн гэрчилгээний хуулбар,

2.1.8 Машин механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар.

Энэ заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан. /

2.2 Тус зөвлөл нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад бичиг баримтыг хянан үзэж, өргөдлийг албан ёсоор хүлээн авснаас хойш ажлын 21 /хорин нэг/ хоногийн дотор Зохицуулах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.3 Зөвлөлийн хуралдаанаас тухайн аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгох боломжгүй гэж үзвэл энэ талаар тодорхой үндэслэлийг зааж, албан бичгээр хариу мэдэгдэнэ.

2.4 Зохицуулах зөвлөлөөс шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэж болно.

2.5 Тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу 3 /гурав/ жилээс доошгүй хугацаагаар олгох бөгөөд Засгийн газрын 2012 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.8 дахь заалтад заасны дагуу Зохицуулах зөвлөлийн дарга гарын үсэг зурж, баталгаажуулна.

2.6 Тусгай зөвшөөрөл сунгуулах тохиолдолд хангагч байгууллагад өргүй байх эсвэл өр барагдуулах график, гэрээтэй байна.

Гурав. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага

3.1 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдэд дор дурдсан шаардлагууд тавигдана.

3.1.1 Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын, цахилгааны инженер техникийн ажилтан тус бүр нэгээс доошгүй /300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн аж ахуйг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй/ байх;

Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

б. Сантехникийн засварчин, цахилгаанчин, хянах, хэмжих хэрэгслийн засварчин зэрэг мэргэжлийн ажилчидтай байх;

в. Тухайлсан байгууламжийг эзэмших буюу ашиглах зөвшөөрөлтэй байх;

г. Ус хангамжийн эх үүсвэрийн харуул хамгаалалт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх;

Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

д. Тоног төхөөрөмж, технологийн ажиллагааны горимын бүдүүвч, холбогдох стандартуудыг бүрдүүлсэн байх;

3.1.2 Ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын инженер, 2500 м³/хоногоос дээш хүчин чадалтай ус хангамжийн байгууламжийн хувьд химичтэй /300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн аж ахуйг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй/ байх;

Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

б. Халдваргүйжүүлэх тоног төхөөрөмжийн засварчин, дээж авагч буюу лаборанттай байх;

в. Тухайлсан байгууламжийг эзэмших буюу ашиглах зөвшөөрөлтэй байх;

г. Ус цэвэршүүлэх технологийн ажиллагааны горим, техник технологи нь шаардлага хангасан, лабораторийн шинжилгээний дүн, мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй, усны чанарын MNS 0900:2005 стандартын шаардлага хангасан байх;

/Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

д. Ус шинжилгээний лабораторитой байх;

е. Ус хангамжийн эх үүсвэрийн ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэгч нь хэрэглэгчид нийлүүлж буй усны дээжийг өдөр бүр авч, лабораторийн шинжилгээ хийх бөгөөд MNS 0900:2005 стандартад нийцсэн усаар хангаж байх;

/Энэ дэд заалтыг Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмсэн. /

ж. Усан сангийн ариутгал халдваргүйжүүлэлтийг MNS 5775:2007 стандартын дагуу хийх бөгөөд ариутгалын бодисын нөөцтэй байх.

/Энэ дэд заалтыг Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмсэн. /

3.1.3 Цэвэр ус дамжуулах шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын хэмжих, хянах хэрэгслийн инженер тус бүр нэгээс доошгүй /300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн аж ахуйг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй/ байх;

/Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

б. Сантехникийн засварчин, гагнуурчинтай байх;

в. Технологийн ажиллагааны горим бүдүүвч, дэвсгэр зураг, техникийн тодорхойлолт зэргийг бүрдүүлсэн байх;

3.1.4 Цэвэр ус түгээх шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын инженертэй /300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн аж ахуйг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй/ байх;

/Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

б. Сантехникийн засварчин, гагнуурчинтай байх;

в. Шугам сүлжээний схем, байршлын зураг, технологийн ажиллагааны горим бүдүүвч, дэвсгэр зураг, техникийн тодорхойлолт зэргийг бүрдүүлсэн байх,

3.1.5 Орон сууцны доторхи цэвэр бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын инженер, дулааны инженер, ээлжийн диспетчер тус тус /300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн аж ахуйг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан, ээлжийн диспетчер тус тус нэгээс доошгүй/ байх;

/Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

б. 300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газраас бусад тохиолдолд 200 өрхийн дунд 1 сантехникийн засварчинтай байх,

/Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

в. Гагнуурчин, цахилгаанчинтай байх;

г. Шугам, сүлжээний схем, байршлын зураг, технологийн бүдүүвч, дэвсгэр зураг, техникийн тодорхойлолттой байх,

д. 300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газраас бусад тохиолдолд айл өрхийн тоо 750-иас дээш байх

/Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

е. Шинээр тусгай зөвшөөрөл авч буй байгууллагуудын хувьд айл өрхүүдийг 100% тоолууржуулсан байх;

ё. Тусгай зөвшөөрөл сунгуулах аж ахуйн нэгж байгууллагуудын хувьд айл өрх, аж ахуйн нэгжүүдийг 80-аас доошгүй хувь тоолууржуулсан байх буюу тоолууржуулалт хийх график, төлөвлөгөөтэй байх;

ж. Орон сууцны засвар үйлчилгээний талаар оршин суугчдын гомдол санал хүлээн авах, шуурхай дуудлагын утас ажиллуулдаг байх;

з. Хэрэглэгчид нь өөр өөр дүүрэгт байрладаг бол байршил тус бүрт ажлын хэсэгтэй байх;

и. Тусгай зөвшөөрөл сунгуулах аж ахуйн нэгж, байгууллага нь хангагч байгууллагаасаа өр, төлбөртэй эсэх тодорхойлолтыг авч хавсаргах.

/Энэ дэд заалтыг Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмсэн. /

3.1.6 Ус дамжуулах төвийн ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын, дулааны инженер тус бүр нэгээс доошгүй байх;

б. Сантехникийн засварчин, цахилгаанчин, гагнуурчинтай байх;

в. Байршлын зураг, технологийн ажиллагааны горим бүдүүвч, дэвсгэр зураг, техникийн тодорхойлолт, ашиглалтад хүлээн авсан акт зэргийг бүрдүүлсэн байх;

3.1.7 Бохир усны гаргалгааны шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын инженертэй /300м3/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн аж ахуйг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй/ байх;

/Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

б. Сантехникийн засварчинтай байх;

в. Холболт, өндөржилтийн зураг, техникийн нөхцөл зэргийг бүрдүүлсэн байх;

3.1.8 Бохир ус цуглуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын инженертэй /300м3/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн аж ахуйг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй/ байх;

/Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

б. Сантехникийн засварчинтай байх;

в. Холболтын зураг, технологийн ажиллагааны горимын бүдүүвч, засвар үйлчилгээний график, дэвсгэр зураг, тодорхойлолт зэргийг бүрдүүлсэн байх;

3.1.9 Бохир усны татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын инженертэй /300м3/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн аж ахуйг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй/ байх;

/Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

б. Сантехникийн засварчинтай байх;

в. Байршлын зураг, технологийн ажиллагааны горим бүдүүвч, дэвсгэр зураг, тодорхойлолт зэргийг бүрдүүлсэн байх;

3.1.10 Бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын инженер /300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн аж ахуйг хариуцан үйл ажиллагаа эрхлэх тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй/, 2500 м³/хоногоос дээш хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн хувьд бактерилогич, технологич, хянах, хэмжих хэрэгслийн инженер тус бүр нэгээс доошгүй байх;

/Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

б. Сантехник, тоног төхөөрөмжийн засварчин, гагнуурчин, цахилгаанчин, хэмжих хянах хэрэгслийн засварчин тус бүр 1-ээс доошгүй байх, дээж авагч буюу лаборанттай байх;

в. Тухайлсан байгууламжийг эзэмших буюу ашиглах зөвшөөрөл, бохир ус цэвэрлэгээний технологийн бүдүүвч, цэвэрлэгээний түвшин, гарах усны найрлага, лабораторийн шинжилгээний дүн, стандартын шаардлагад нийцсэн эсэх зэргийг баталгаажуулах бичиг баримттай байх;

г. Бохир ус зөөврийн автомашин, эксковатор, зөөврийн гагнуур, усны шинжилгээний суурин буюу зөөврийн лабораторитой байх;

3.1.11. Ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын буюу хэмжих хянах хэрэгслийн, цахилгааны, гидробиологич инженер, техникийн ажилтан тус бүр нэгээс доошгүй байх,

б. Шаардлагатай тохиолдолд химич-бактериологичтой байх;

в. Сантехникийн засварчин, гагнуурчинтай байх;

г. Аваар, засвар үйлчилгээний зориулалтын автомашин, автокран, эксковатор, зөөврийн гагнуурын аппарат, цэвэр, бохир ус шинжилгээний суурин болон зөөврийн лаборатори, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн нөөцтэй байх;

3.1.12 Хот, суурины ус түгээх байрны ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Төвлөрсөн шугамын ус түгээх байрны хувьд сантехникийн засварчин, ус түгээгчтэй байх, хангагч байгууллагатай байгуулсан гэрээтэй байх;

б. Гүний ус түгээх байрны хувьд ус түгээгчтэй байх, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ус ашиглуулах дүгнэлт, сав газрын захиргаанаас олгосон ус ашиглах зөвшөөрөл, мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт, ажлын байрны дүгнэлттэй байх;

в. Зөөврийн ус түгээх байрны хувьд ус түгээгчтэй байх, хангагч байгууллагатай байгуулсан гэрээтэй байх;

3.1.13 Зөөврийн ус хангамжийн үйлчилгээний чиглэлээр:

а. С ангиллын жолооч, ус түгээгчтэй байх;

б. Ус зөөврийн автомашинтай байх;

3.1.14 Бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээний чиглэлээр:

а. С ангилалын жолооч байх;

б. Бохир ус зөөвөрлөх автомашинтай байна. Хэрэв бохир ус зөөвөрлөх өөрийн эзэмшлийн автомашингүй бол иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хийсэн гэрээний үндсэн дээр ашиглаж болох бөгөөд гэрээний хуулбарыг хавсаргана.

/Энэ дэд заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан. /

3.2 Энэ зүйлд заасан үйл ажиллагааны чиглэл бүрээр заагдсан тусгай шаардлагаас гадна салбарын хууль, тогтоомж болон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан норм, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тусгай зориулалтын технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, машин механизмтай байх, гарч болзошгүй аварь, ослоос урьдчилан сэргийлэх нөөцтэй байх, өөрийн эзэмшлийн өндөр хүчин чадлын машин механизмтай байх, машин механизмыг гэрээгээр болон түрээсээр авч ашиглах нөхцлийг бүрдүүлсэн байх зэрэг нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагуудад тавигдах нийтлэг шаардлага болно.

3.3 Инженер техникийн ажилчдын зохих хувь нь тухайн мэргэжлээрээ мэргэшсэн, тодорхой ажлын туршлагатай байвал зохино.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

4.1 Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сунгуулах хүсэлтээ гаргаж, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

4.2 Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө сунгуулах материалаа бүрдүүлж ирүүлээгүй бол гэрчилгээнд заасан хугацаанаас хойш тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцож, Зохицуулах зөвлөлийн тогтоолоор баталгаажуулан холбогдох байгууллагад мэдээлнэ.

/Энэ хэсгийг Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмсэн. /

4.3 Тусгай зөвшөөрөл цуцлагдсан тохиолдолд үйл ажиллагаагаа дахин эхлүүлэх бол тусгай зөвшөөрөл шинээр авах нөхцлөөр материалыг иж бүрнээр бүрдүүлэн Зохицуулах зөвлөлд ирүүлнэ.

/Энэ хэсгийг Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмсэн. /

4.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд Зохицуулах зөвлөлөөс үйл ажиллагааны чиглэл тус бүрээр хяналт тавьж ажиллана.

4.5 Тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж байгууллага нь тусгай зөвшөөрлийн гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлсэн байна.

/Энэ хэсэгт Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан. /

4.6 Тусгай зөвшөөрөл сунгуулах бол Аж ахуйн нэгж байгууллагын сүүлийн улирлын санхүүгийн тайлан тэнцэл, татварын байгууллагын тодорхойлолт, аудитын дүгнэлт, Зохицуулах зөвлөлөөс батлагдсан маягтын дагуу санхүүгийн мэдээлэл ирүүлнэ.

4.7 Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

Тав. Бусад

5.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, хүний нөөц, техник, технологи, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулахтай холбогдсон харилцааг тусдаа журмаар зохицуулна.

--- о О о ---

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2014 оны 7 дугаар сарын 09-ны өдрийн 18 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

УС ОЛБОРЛОН, ЦЭВЭРШҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү баримт бичиг нь цэвэр ус олборлох, цэвэршүүлэх, савлан борлуулах, зөөврийн ус хангамжийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй байдалд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Нөхцөл, шаардлагыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн баримт бичиг дээр үндэслэсэн болно.

Хоёр. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг, тусгай зөвшөөрөл олгох

2.1 Цэвэр ус олборлох, цэвэршүүлэх, зөөврийн ус хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж байгууллага нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

2.1.1 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааны төрөл, ангиллыг тодорхой зааж, тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл

2.1.2 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ

2.1.3 Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гарч, улсын тэмдэгтийн хураамж төлснөөр тусгай зөвшөөрөл олгогдоно./

/Энэ заалтад Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. /

2.1.4 Мэргэжлийн Хяналтын Газрын ажлын байрны дүгнэлт

2.1.5 Мэргэжлийн Хяналтын Газрын усны шинжилгээний дүгнэлт

2.1.6 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ус ашиглуулах дүгнэлт, сав газрын зөвлөлөөс олгосон ус ашиглах зөвшөөрөл

2.1.7 Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд Гадаадын хөрөнгө оруулалтын газраас олгосон гэрчилгээний хуулбар, тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар

2.1.8 Аж ахуйн нэгж байгууллагын сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан тэнцэл, аудитын дүгнэлт, татварын байгууллагын тодорхойлолт, шинээр байгуулагдаж байгаа аж ахуйн нэгжийн хувьд эхлэлтийн баланс, мөн Зохицуулах зөвлөлөөс батлагдсан маягтын дагуу жил, улирлаар гаргасан санхүүгийн мэдээлэл байна.

2.1.9 Инженер техникийн ажилтан нэг бүрийн диплом, гэрчилгээ, батламж, зөвлөх инженерийн гэрчилгээний хуулбар, мэргэшсэн инженерийн мэргэшлийн зэргийн гэрчилгээний хуулбар

2.1.10 Машин механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар.

2.2 Тус зөвлөл нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад бичиг баримтыг хянан үзэж, өргөдлийг албан ёсоор хүлээн авснаас хойш ажлын 21 /хорин нэг/ хоногийн дотор Зохицуулах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.3 Зөвлөлийн хуралдаанаас тухайн аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгох боломжгүй гэж үзвэл энэ талаар тодорхой үндэслэлийг зааж, албан бичгээр хариу мэдэгдэнэ.

2.4 Зохицуулах зөвлөлөөс шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргагчийн бичиг баримтыг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэж болно.

2.5 Тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу 3 /гурав/ жилээс доошгүй хугацаагаар олгох бөгөөд Засгийн газрын 2012 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.8 дахь заалтад заасны дагуу Зохицуулах зөвлөлийн дарга гарын үсэг зурж, баталгаажуулна.

Гурав. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага

3.1 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдэд доор дурдсан нөхцөл шаардлагууд тавигдана.

3.1.1 Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр:

- а. Ус хангамж, ариутгах татуургын инженер техникийн ажилтантай байх;
- б. Тоног төхөөрөмжийн засварчинтай байх;
- в. Тухайлсан байгууламжийг эзэмших буюу ашиглах зөвшөөрөлтэй байх;
- г. Үйлдвэрийн тоног төхөөрөмж, технологийн ажиллагаа нь холбогдох стандарт, технологийн шаардлага хангасан байх;

3.1.2 Ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

- а. Технологич инженер, хүнсний эрүүл ахуйч буюу химичийн аль нэг байх;
- б. Тоног төхөөрөмжийн засварчин, лаборанттай байх;
- в. Тухайлсан байгууламжийг эзэмших буюу ашиглах зөвшөөрөлтэй байх;
- г. Ус цэвэршүүлэх технологийн ажиллагааны горим бүдүүвч, тухайн байгууллагын лабораторийн шинжилгээний бүртгэлийн дэвтэртэй байх;
- д. Усны шинжилгээний лабораторитой байх;

3.2 Энэ зүйлд заасан үйл ажиллагааны чиглэл бүрээр заагдсан тусгай шаардлагаас гадна салбарын хууль, тогтоомж болон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан норм, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тусгай зориулалтын технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, машин механизмтай байх, гарч болзошгүй аварь, ослоос урьдчилан сэргийлэх шуурхай албаны төлөвлөгөөтэй байх зэрэг нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагуудад тавигдах нийтлэг шаардлага болно.

3.3 Инженер техникийн ажилчдын зохих хувь нь тухайн мэргэжлээрээ мэргэшсэн, тодорхой ажлын туршлагатай байвал зохино.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

4.1 Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сунгуулах хүсэлтээ гаргаж, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

4.2 Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө сунгуулах материалаа бүрдүүлж ирүүлээгүй бол гэрчилгээнд заасан хугацаанаас хойш тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцож, Зохицуулах зөвлөлийн тогтоолоор баталгаажуулан холбогдох байгууллагад мэдээлнэ.

/Энэ хэсгийг Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмсэн. /

4.3 Тусгай зөвшөөрөл цуцлагдсан тохиолдолд үйл ажиллагаагаа дахин эхлүүлэх бол тусгай зөвшөөрөл шинээр авах нөхцлөөр материалыг иж бүрнээр бүрдүүлэн Зохицуулах зөвлөлд ирүүлнэ.

/Энэ хэсгийг Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмсэн. /

4.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд Зохицуулах зөвлөлөөс үйл ажиллагааны чиглэл тус бүрээр хяналт тавьж ажиллана.

4.5 Тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн байгууллага нь тусгай зөвшөөрлийн гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлсэн байна.

/Энэ хэсгийг Зохицуулах зөвлөлийн 2014.12.02-ны өдрийн 66 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан. /

4.6 Тусгай зөвшөөрөл сунгуулах бол Аж ахуйн нэгж байгууллагын сүүлийн улирлын санхүүгийн тайлан тэнцэл, татварын байгууллагын тодорхойлолт, аудитын дүгнэлт, Зохицуулах зөвлөлөөс батлагдсан маягтын дагуу санхүүгийн мэдээлэл ирүүлнэ.

4.7 Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

Тав. Бусад

5.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, хүний нөөц, техник, технологи, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулахтай холбогдсон харилцааг тусдаа журмаар зохицуулна.

--- оОо ---